ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Эрдэнэбүрэн сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ХОА-2022/100/НА/-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2022 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn<br>Тунгалаг бүртгэл Аудит ХХК-ны захирал<br>Аудитор: Ч. Мөнхцоож<br>Утас: 99028555<br>цахим хаяг: munhuu8555@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 6
3. Аудитын тайлан ........ 8
**3.1 Ерөнхий зүйл** ........ 8
**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт** ........ 8
**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал** ........ 9
**3.4 Материаллаг байдал** ........ 9
**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга** ........ 9
**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв** ........ 10
**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг** ........ 11
**3.8 Аудитын гол асуудал** ........ 11
**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 11
**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 11
**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 11
**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 12
**4. Аудитын илрүүлэлт** ........ 12
4.1 Залруулсан алдаа ........ 12
4.2 Төлбөрийн акт ........ 12
4.3 Албан шаардлага ........ 12
Албан шаардлага өгөөгүй ........ **Error! Bookmark not defined.**
4.4 Зөвлөмж ........ 12
**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл** ........ 13


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.03.13 №

танай ____________-ны №____________-т

ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН

ЭРХЛЭГЧ М.ЦАГААНЦООЖ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбүрэн сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрдэнэбүрэн сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын эзэмшлийн эргэлтийн сүргийн мал амьтадыг данс бүртгэлд тусгаагүй, сүргийн эргэлт нас дэвшилтийг тооцоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7,4-д" Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтанд бичилт хийж бүрдүүлнэ." гэсэнтэй нийцэхгүй, иж бүрэн байх,тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

.1020417

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 29,673,439 | 25,584,912 |
| 33 | **АВЛАГА** | 2,341,991 | 572,253 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,075,184 | 305,446 |
| 335 | **Бусад авлага** | 266,807 | 266,807 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 266,807 | 266,807 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 27,331,448 | 25,012,659 |
| 351 | **Түүхий эд материал** | 12,000 | 73,600 |
| 35130 | Эм боох материал | 12,000 | 73,600 |
| 354 | **Хангамжийн материал** | 26,720,178 | 24,279,789 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 33,500 | 244,000 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,739,064 | 3,977,034 |
| 35460 | Хүнсний материал | 5,464,913 | 2,694,658 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 18,482,701 | 17,364,097 |
| 35600 | Мал амьтад | 599,270 | 659,270 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 298,597,981 | 288,509,394 |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 298,597,981 | 288,509,394 |
| 392 | **Биет хөрөнгө** | 291,859,231 | 281,926,894 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 294,534,174 | 294,534,174 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (25,425,612) | (35,838,417) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 34,165,338 | 37,165,338 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (22,597,071) | (23,641,621) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,703,261 | 30,703,261 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (23,409,001) | (24,883,983) |
| 39217 | Ном | 3,888,143 | 3,888,143 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 6,738,750 | 6,582,500 |
| 39301 | Программ хангамж | 625,000 | 625,000 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (156,250) | (312,500) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 6,270,000 | 6,270,000 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 328,271,420 | 314,094,307 |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 44,689 | 401,976 |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 44,689 | 401,976 |
| 413 | **Өглөг** | 44,689 | 401,976 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 44,689 | 401,976 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 328,226,731 | 313,692,330 |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 328,226,731 | 313,692,330 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 100,020,356 | 100,020,356 |
| 51101 | Өмч: - төрийн | 100,020,356 | 100,020,356 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | (58,265,650) | (72,800,051) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (58,265,650) | (58,265,650) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (13,450,784) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 286,472,026 | 286,472,026 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 328,271,420 | 314,094,307 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 217,261,200 | 215,561,153 |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 13,503,800 | 3,073,600 |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 13,503,800 | 3,073,600 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 13,194,800 | 3,073,600 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 13,194,800 | 3,073,600 |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **203,757,400** | **212,487,553** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 178,460,200 | 188,252,000 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 178,460,200 | 188,252,000 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 303,853 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 303,853 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 25,297,200 | 23,931,700 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 25,297,200 | 23,931,700 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **215,721,852** | **229,011,937** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **215,434,425** | **229,011,937** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 205,858,925 | 203,178,319 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 136,587,598 | 140,833,583 |
| 210101 | Үндсэн цалин | 92,567,909 | 111,823,311 |
| 210102 | Нэмэгдэл | 35,175,265 | 19,691,113 |
| 210104 | Урамшуулал | 8,844,424 | 9,319,159 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,991,407 | 18,315,374 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,577,649 | 12,718,153 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,354,976 | 1,400,276 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,083,984 | 1,120,221 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 264,840 | 276,171 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,709,959 | 2,800,552 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,018,200 | 22,654,230 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,379,442 | 1,254,230 |
| 210302 | Түлш, халаалт | 23,447,658 | 21,400,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 785,800 | 2,141,102 |
| 210401 | Бичиг хэрэг | 85,800 | 1,304,634 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 632,000 | 456,800 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 16,300 | 42,800 |
| 210404 | Ном, хэвлэл | 42,200 | 25,500 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,500 | 12,000 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 299,368 |
| **2105** | **Нормативт зардал** | 11,757,030 | 3,904,939 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,978,200 | 39,900 |
| 210502 | Хоол, хүнс | 8,780,530 | 3,822,339 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 998,300 | 42,700 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 498,000 |
| 210604 | Урсгал засвар | - | 498,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 54,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 54,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 200,000 | 359,900 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 35,900 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000 | 324,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 14,518,891 | 14,417,191 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,575,993 | 1,328,604 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,942,898 | 13,088,587 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,575,500 | 25,833,618 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 9,575,500 | 25,833,618 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,575,500 | 25,833,618 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,539,348** | **(13,450,784)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,539,348** | **(13,450,784)** |

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Төгрөгөөр

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 100,020,356 | 286,472,026 | (58,265,650) | | 328,226,731 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 100,020,356 | 286,472,026 | (58,265,650) | - | 328,226,731 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 100,020,356 | 286,472,026 | (58,265,650) | - | 328,226,731 |
| D01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 100,020,356 | 286,472,026 | (58,265,650) | - | 328,226,731 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 100,020,356 | 286,472,026 | (58,265,650) | - | 328,226,731 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (13,450,784) | | (13,450,784) |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 100,020,356 | 286,472,026 | (71,716,434) | - | 314,775,947 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | 203,757,400 | 212,512,753 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 203,757,400 | 212,512,753 |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 178,460,200 | 188,277,200 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 178,460,200 | 188,277,200 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 303,853 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 303,853 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 25,297,200 | 23,931,700 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 25,297,200 | 23,931,700 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | 203,757,400 | 212,512,753 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 203,757,400 | 212,512,753 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 194,181,900 | 186,679,135 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 137,670,984 | 137,431,302 |
| 210101 | Үндсэн цалин | 81,251,500 | 79,324,063 |
| 210102 | Нэмэгдэл | 48,613,560 | 49,527,697 |
| 210104 | Урамшуулал | 7,805,924 | 8,579,542 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 18,193,216 | 18,715,300 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,671,016 | 13,045,500 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,380,500 | 1,417,600 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,104,400 | 1,099,000 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 276,200 | 318,600 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,761,100 | 2,834,600 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,227,100 | 23,833,600 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,033,700 | 2,033,600 |
| 210302 | Түлш, халаалт | 22,793,400 | 21,400,000 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000 | 400,000 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 758,000 | 3,082,153 |
| 210401 | Бичиг хэрэг | 58,600 | 1,064,100 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 511,100 | 456,800 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 48,000 | 42,800 |
| 210404 | Ном, хэвлэл | 33,600 | 29,800 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 303,853 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 106,700 | 1,184,800 |
| **2105** | **Нормативт зардал** | 10,340,600 | 1,696,280 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,620,400 | 31,400 |
| 210502 | Хоол, хүнс | 8,123,100 | 1,367,780 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 597,100 | 297,100 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 70,100 | 98,000 |
| 210604 | Урсгал засвар | 70,100 | 98,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 60,700 | 54,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 60,700 | 54,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 327,600 | 467,600 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 127,600 | 143,600 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000 | 324,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,533,600 | 1,300,900 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,533,600 | 1,300,900 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,575,500 | 25,833,618 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 9,575,500 | 25,833,618 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,575,500 | 25,833,618 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 203,759,909 | 194,181,900 | 186,375,282 | 186,375,282 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 203,759,909 | 194,181,900 | 186,375,282 | 186,375,282 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 203,759,909 | 194,181,900 | 186,375,282 | 186,375,282 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 136,727,700 | 137,670,984 | 137,431,302 | 137,431,302 |
| 210101 | Үндсэн цалин | 81,251,500 | 81,251,500 | 74,917,502 | 79,324,063 |
| 210102 | Нэмэгдэл | 46,368,600 | 48,613,560 | 53,726,000 | 49,527,697 |
| 210104 | Урамшуулал | - | - | 8,787,800 | 8,579,542 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 18,459,400 | 18,193,216 | 18,715,300 | 18,715,300 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,989,000 | 12,671,016 | 12,992,500 | 13,045,500 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,367,200 | 1,380,500 | 1,430,700 | 1,417,600 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,093,800 | 1,104,400 | 1,144,600 | 1,099,000 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 274,500 | 276,200 | 286,100 | 318,600 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,734,900 | 2,761,100 | 2,861,400 | 2,834,600 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,227,100 | 25,227,100 | 23,833,600 | 23,833,600 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,033,700 | 2,033,700 | 2,033,600 | 2,033,600 |
| 210302 | Түлш, халаалт | 22,793,400 | 22,793,400 | 21,400,000 | 21,400,000 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000 | 400,000 | 400,000 | 400,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 758,000 | 758,000 | 2,778,300 | 2,778,300 |
| 210401 | Бичиг хэрэг | 58,600 | 58,600 | 1,064,100 | 1,064,100 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 511,100 | 511,100 | 456,800 | 456,800 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 48,000 | 48,000 | 42,800 | 42,800 |
| 210404 | Ном, хэвлэл | 33,600 | 33,600 | 29,800 | 29,800 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 106,700 | 106,700 | 1,184,800 | 1,184,800 |
| **2105** | **Нормативт зардал** | 19,917,309 | 10,340,600 | 1,696,280 | 1,696,280 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,620,400 | 1,620,400 | 31,400 | 31,400 |
| 210502 | Хоол, хүнс | 17,700,209 | 8,123,100 | 1,367,780 | 1,367,780 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 596,700 | 597,100 | 297,100 | 297,100 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 70,100 | 70,100 | 98,000 | 98,000 |
| 210604 | Урсгал засвар | 70,100 | 70,100 | 98,000 | 98,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 60,700 | 60,700 | 54,000 | 54,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 60,700 | 60,700 | 54,000 | 54,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 343,600 | 327,600 | 467,600 | 467,600 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 143,600 | 127,600 | 143,600 | 143,600 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000 | 200,000 | 324,000 | 324,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,196,000 | 1,533,600 | 1,300,900 | 1,300,900 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,196,000 | 1,533,600 | 1,300,900 | 1,300,900 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 203,757,400.00 | 203,757,400.00 | 210,306,982.00 | 224,153,582.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 178,530,300.00 | 178,530,300.00 | 186,375,282.00 | 186,375,282.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 178,530,300.00 | 178,530,300.00 | 162,443,582.00 | 162,443,582.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 25,227,100.00 | 25,227,100.00 | 23,931,700.00 | 23,931,700.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 25,227,100.00 | 25,227,100.00 | 23,931,700.00 | 23,931,700.00 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | - | - | 0.000 | 13,846,600.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | - | 0.000 | 13,846,600.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | - | - | 1.000 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | - | - | 1.000 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | - | - | 11.000 | 11.00 |
| 620001 | Удирдах ажилтан | - | - | 1.000 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | - | - | 6.000 | 6.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | - | - | 4.000 | 4.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | - | - | 11.000 | 11.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | - | - | 7.000 | 7.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | - | - | 4.000 | 4.00 |

**2.6. Нэмэлт санхүүжилтийн тайлан** **төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | 303,853.00 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | 303,853.00 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 303,853.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | - | 303,853.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 303,853.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 303,853.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 303,853.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 303,853.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Эрдэнэбүрэн сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны мэдээллийг бүрэн оруулах, төсвийн хэмнэлтэй холбоотой асуудлыг зөвлөмжид тусгасан болно.

Аудитыг Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны аудитор Ч. Мөнхцоож 2022 оны 3 дугаар сарын 4-нээс 2021 оны 3 дугаар сарын 8–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 20-ний өдрийн 01 тоот албан бичигтэй боловч Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 4-ны өдөр ирүүлж Төсвийн тухай хуульд заасан цагалбарт хугацааг мөрдөн ажиллаагүй болно.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

"Хүүхдийн хөгжил хэрэгцээ, хандлагад нийцүүлэн хүүхэд бүрийг өв тэгш хөгжүүлнэ" гэсэн үндсэн зорилгын дор үйл ажиллагаагаа зохион байгуулсан байна.

Дэлхий нийтэд тархаад байгаа цар тахал Ковид-19 өвчин Монгол Улсад гарсантай холбоотойгоор боловсролын бүх шатны байгууллагын үйл ажиллагааг хааж хувилбарт сургалт хэлбэрээр зохион байгуулах шийдвэр гарсантай холбоотойгоор сургалтын үйл ажиллагааг хувилбарт хэлбэртэйгээр зохион байгуулан ажиллаж хамран сургалтын хүрээнд 132 хүүхэд, 11 багш ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

"Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол гарсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бөгөөд 2018 оноос хойш шинэчлэлт хийгдээгүй харин жил бүр сайжруулалт хийсэн байна.

2021 онд аймгийн Засаг даргын тамгын газраас хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн болон Засаг даргын дэргэдэх дотоод аудитын албанаас санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй, төрийн аудитын газраас 2020 оны санхүүгийн тайланд аудит хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэбүрэн сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны батлагдсан төсвийн 198362,3 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 3967,2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3173.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэбүрэн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14177.1 мянган төгрөгөөр буурсан байна. Тайланд онд орон нутгийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэн 3000,0 мянган төгрөгийн камер бусад тохөөрөмжийг авснаар үндсэн хөрөнгө нэмэгдсэн болон үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүн 13088,5 мянган төгрөгөөр өссөн зэрэг нь нийт хөрөнгийн дүн буурахад нөлөөлсөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Тайлант онд авлага өмнөх оноос 1769.7 мянган төгрөгөөр буурсан. Энэ нь өмнөх оны НДШ болон ХХОАТ-н авлага буурсантай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 25012,6 мянган төгрөг болж 2318,7 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь аж ахуйн материал 1238,0 мянган төгрөгөөр өсөж, хүнсний материалын үлдэгдэл 2770,3 мянган төгрөгөөр тус тус өссөн зэргээс хамаарчээ.

Тайлангийн хугацаанд төсвийн хөрөнгөөр 6371,5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүйгээр БС-н Газраас 73,6 мянган төгрөгийн ариутгал, халдваргүйн материал хүлээн авч данс бүртгэлд тусгасан болон 8897,5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 370185,9 мянган төгрөг, оны эцэст 373185,9 мянган төгрөг болж 3000,0 мянган төгрөгөөр өссөн нь сумын ОНХС-аас санхүүжүүлэн өрөө тасалгаа, гадна орчны хяналтын камер бэлтгэн нийлүүлсэнтэй холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 357,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Энэ нь цалингийн программд оруулсан нэмэгдэл цалингийн хувь тооцоолсон дүн зөрүүтэйгээс НДШ -н 401,9 мянган төгрөгийн өглөгтэй болохыг илрүүлэн тайланд залруулга хийлээ. Ингэснээр өр төлбөрийн дүн өссөн болно.

Тайлангийн хугацаанд цэвэр хөрөнгийн дүн буурсан, авлага өссөн өглөг нэмэгдсэнтэй холбоотойгоор хуримтлагдсан үр дүн 13450,7 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны эхний үлдэгдэл 328226,7 мянган төгрөг байснаа оны эцэст 313692,3 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүнтэйгээс хамааралтай байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрдэнэбүрэн сумын цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 212183,7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 212183,7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 212183,7 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 212183,7 мянган төгрөгийн төсөв баталж 188252,0 мянган төгрөгийг улсын төсвөөс төсвөөс, 23931,7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 188252,0 мянган төгрөгийг улсын төсвөөс төсвөөс, 23931,7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс нийт 212183,7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 25833,6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 186375,2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 186375,2 мянган төгрөг болж төсвийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт дансаар БСГазраас ариутгалын зардал болон ковидын халдвар хамгааллын хэрэгсэлийн нөөц бүрдүүлэлэхэд 303,8 мянган төгрөгийн орлого орж тус тусын зориулалтын дагуу зарцуулагджээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого зарлагын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа 151 мэдээллийг хугацаандаа оруулж, хугацаа хожимдож мэдээлэл байхгүй байна.

Гэвч аудитын явцад бид улирлын тайлан, худалдан авах ажиллагааны мэдээллийг цаг хугацаандаа шилэн дансанд мэдээлсэн эсэхийг хянахад жилийн эцсийн санхүүгийн тайлангийн 24 мэдээлэл оруулахаас 22 хугацаандаа, 2 хугацаа хоцорсон байна.

Бидний хянаснаар 5,0 сая төгрөгөөс дээших үнийн дүнтэй 2 ажил гүйлгээний 24076,6 мянган төгрөгийн мэдээллийг уг сайтад байршуулахаар байна. Үүнээс 1 ажил гүйлгээ мэдээлэгдэж, 1 ажил гүйлгээ мэдээлэгдээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн дүн 80 орчим хувьтай байна. гэж үзлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар үр дүнгийн урамшууллыг ажлын үр дүнгээр бус хавтгайруулан олгосон, малыг зах зээлийн үнээр үнэлж данс бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчил дутагдлыг арилгах зөвлөмж хүргүүлжээ. Энэ зөвлөмжийн дагуу тайлант онд үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгоогүй бөгөөд хэмнэгдсэн цалингийн зардлыг буцаан төвлөрүүлсэн байна. Харин малыг данс бүртгэлд бүртгэх зах зээлийн үнээр үнэлэх асуудал хийгдээгүй. Учир нь жилийн эцсээр малын тооллогын картаар нийт 85 толгой мал, түүний дотор хонь

50 ямаа 35 гэж тоолсон боловч нас хүйсээр ангилаагүй тул бодитойгоор зах зээлийн үнэлгээ хийх боломжгүй байжээ. Иймээс зөвлөмжийн хэрэгжилтийг 60 хувьтай хэрэгжсэн гэж үзэж байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байгууллагын эзэмшилд байгаа гэх эргэлтийн мал амьтадын тооллогыг дахин хийж хонь ямаа гэж ангилан нас, хүйс, төл мал гэж ялган үнэлж, данс бүртгэлд тусгах асуудлыг дараагийн аудитаар дахин хянах нь зөв гэж үзлээ.

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 21826,0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3188,5, мянган төгрөгийн алдааг залруулж, өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг хангаагүйтэй холбоотой 1 албан шаардлага өгч, шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсвийн 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүйтэй холбоотой 18637,5 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 2 төрлийн зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Амралтын мөнгөнөөс суутгах НДШ-н тооцоо буруугаас 1548,9 мянган төгрөгийн өглөг дутуу бүртгэсэн

2. ХХОАТ-н авлага дутуу бүртгэсэн 290,5 мянган төгрөг

3. НДШ-н өглөг 401,9 мянган төгрөгийг бүртгээгүй

4. БСГ-аас үнэ төлбөргүй ирсэн 73,6 мянган төгрөгийн автомакс ариутгалын бодис орлого бүртгээгүй

5. Цалингийн зардал дутуу тооцоолсон 2422,4 мянган төгрөг

***Шийдвэрлэсэн нь:*** Аудитын явцад дээрхи 3188,5 мянган төгрөгийн алдааны залруулга хийхийг шалгагдагч байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, шалгагдагч байгууллага тухайн бүртгэлийг аудитын явцад залруулах хүсэлтээ 2022 оны 3 дугаар сарын 13-ны 02 тоот албан бичгээр ирүүлсэн тул залруулгыг тайланд хийлээ.

**4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Өмнөх аудитаар эргэлтийн малыг зах зээлийн үнээр үнэлж данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлсэн боловч уг зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэн сүргийн эргэлт тооцон хонь ямаа гэж ангилахаас гадна малын төрөл бүрээр нас хүйсээр ангилан бүртгэж, нас дэвшилт, төлийн орлого, зарцуулалтаар бүртгэн тайлагнаж байх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**4.4.1 Шилэн данстай холбоотой асуудал**

4.4.1. Илрүүлэлт: Шилэн дансны хуульд заасны дагуу сар бүрийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээших зарлагын ажил гүйлгээ, авлага , өглөг үүссэн шалтгаан тайлбарын мэдээллийг байршуулаагүй байна.

4.4.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлэх гэсэн заалтуудыг мөрдөн холбогдох мэдээллийг тухай бүрд мэдээлж хэвших.

### 4.4.2 Төсвийн хэмнэлттэй холбоотой асуудал

4.4.1. Илрүүлэлт: "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай " Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах, цахилгаан дулааны эрчим хүч цэвэр усны хэрэглээний 20-оос доошгүй хувийн хэмнэлт гаргах,

4.4.2. Өгсөн зөвлөмж: "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай " Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

**Мянган .төг**

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Эрдэнэбүрэн сумын цэцэрлэг | 7 | 21,826.0 | 4 | 3,188.5 | 0 | 0 | 1 | 0.0 | 2 | 18637.5 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР Огноо:2022. 03.13

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН Огноо: 2022. 03.13

**БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР Ч.МӨНХЦООЗ Огноо: 2022. 03.13

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 3 сарын 15 өдөр Дугаар____ Ховд

*Зөрчил арилгах тухай*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрдэнэбүрэн сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар эргэлтийн малыг зах зээлийн үнээр үнэлж данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлсэн боловч уг зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул зөвлөмжийг хэрэгжүүлэн сүргийн эргэлт тооцон, малын төрөл, нас, хүйсээр ангилан бүртгэж, нас дэвшилт, төлийн орлого, зарцуулсан зориулалтаар анхан шатны баримт хөтлөн, данс бүртгэлд тусгаж, тайлан гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7,4-д" Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтанд бичилт хийж бүрдүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хувиарлалт гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*" Гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эргэлтийн малыг зах зээлийн үнээр үнэлж данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг албан тоотоор 2022 оны 6 дугаар сарын 15-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг цэцэрлэгийн эрхлэгч М.Цагаанцоож, нягтлан бодогч Л.Нямгарав нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

Ахлах аудитор [signature] Ч.Мөнхцоож



0210439